

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

/Төсөвт байгууллагууд нь Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд тусгасан төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна./

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99014227, 98825995, 89330330, 90066888, 99054581 дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ: Завхан аймгийн Аудитын газар Улиастай сум, Жинст багийн Нутгийн захиргааны ордон 309,310 тоот өрөө

Гүйцэтгэсэн :

Ахлах аудитор

Аудитор Б.Дагвасүрэн
Б.Жалбаа
Б.Мөнхнасан
Г.Чулуунбаатар
Хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Уламбаяр

Аудитын менежер Г.Хашцэцэг

2018.06.28

➤ Товчилсон үгийн тайлбар.....	3
➤ Аудит хийх үндэслэл, аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй..	4
➤ Ерөнхий мэдээлэл	5
➤ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх аймаг, сумын үндсэн чиглэлтэй уялдсан байна.	6- 13
➤ Татварын орлогуудын төлөвлөгөөг бүх нэр төрөл дээр жигд биелүүлэх ажилд сумын удирдлагууд, татварын байцаагч нар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох шаардлагатай байна.....	14- 15
➤ ОНХС-ийн хөрөнгөөр урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.....	16-17
➤ СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч, албан шаардлагын биелэлтийг хангах шаардлагатай байна.....	18-19
➤ Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн	
❖ ИТХ-ын үйл ажиллагааны үр дүн.....	19-20
❖ Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны үр дүн.....	20-22
❖ Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны үр дүн.....	23-26
❖ Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны үр дүн.....	26-28
❖ Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны үр дүн.....	29-31
❖ Соёлын төвийн үйл ажиллагааны үр дүн.....	32-35
➤ Зөвлөмж	
❖ ИТХ.....	36
❖ ЗДТГ.....	37
❖ Ерөнхий боловсролын сургууль.....	38
❖ Хүүхдийн цэцэрлэг.....	39
❖ Эрүүл мэндийн төв.....	40
❖ Соёлын төв.....	41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- АИТХ - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- ЗДТГ - Засаг даргын тамгын газар
- ИТХХ - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаан
- ОНХС - Орон нутгийн хөгжлийн сан
- БИНХ - Багийн Иргэдийн Нийтийн Хурал
- ҮАГ - Үндэсний Аудитын Газар
- ЗГ - Засгийн газар
- АДБОУС - Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
- УТХО - Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
- ХЭДС - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- ЖДҮДС - Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
- БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- БӨХ - Байгууллагын өөрийн хөрөнгө
- ТХ - Төсөл хөтөлбөр
- ОНЗС - Орон нутгийн замын сан
- БХНСАХЗ - Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
- СХС - Сум хөгжүүлэх сан
- ЕБС - Ерөнхий боловсролын сургууль
- НӨАТ - Нэмэгдсэн өртгийн албан татвар

1.Аудит хийх үндэслэл

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

“Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Сумын засаг даргын мөрийн хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, үр дүн
- Орон нутгийн татварын орлого, ОНХС, СХС болон төсөвт байгууллагуудын орлого бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн
- Хөрөнгө оруулалт болон хөтөлбөр арга хэмжээний үр дүн

3. Хамарсан хүрээ

Аудитад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөж эхэлсэн 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш боловсруулан баталж, хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд сумын ИТХ, Засаг дарга түүний харьяа агентлаг, байгууллага холбогдох ажилтнуудыг хамруулан сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн ажлын үр дүн, төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

4.Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан шалгагдагч холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, байгууллагын санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

- Төрийн Аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- ТБОНӨХБАҮХАТухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам эрхийн акт
- Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөө, хэрэгжилт

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг дарга бөгөөд тэргүүлэх аудитор Л.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Г.Хашцэцэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, Аудитор Б.Жалбаа, Б.Мөнхнасан, Г.Чулуунбаатар нар гүйцэтгэлээ.

7. Аудитын хугацаа,

Аудитыг 2018 оны 06 сарын 01-нээс 2018 оны 07 сарын 05-ны дотор гүйцэтгэлээ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна шалгагдагч байгууллагын саналыг тусгав.

8. Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, бий болгосон үр өгөөж, акт баримтууд хавсралт хэсгүүдээс бүрдсэн. Аудитын тайлангийн төслийг сумын төсвийн ерөнхийлөн захирагч, төсөвт байгууллагуудын менежер нарт танилцуулан саналыг авч хуулийн дагуу тавигдсан саналыг тайланд тусган боловсруулж зөвлөлийн хуралд оруулан тайланг эцсийн байдлаар холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл:

СУМЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Тус сум 756 өрхийн 2671 хүн амтай, засаг захиргааны 6 багтайгаар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Сумын дүнгээр 2015 оны байдлаар 652 малтай өрх, 387 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж,газар тариалангийн үйлдвэрлэлээр жилийн хэрэгцээт төмс хүнсний ногоо болон чацарганыг орон нутагтаа үйлдвэрлэж байна.

Сумын хэмжээнд төсвийн 6 байгууллага, хувийн 13 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж ,Ерөнхий боловсролын сургуульд 368 сурагч, цэцэрлэгт 106 хүүхэд суралцаж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2016 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд аудит хийх явцад сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг нягталж үзэхэд дараах байдалтай байна.

Бүлэг.1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх аймаг, сумын үндсэн чиглэлтэй уялдсан байна.

1.1 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийг төлөвлөж, боловсруулахдаа Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нягтлахад 4 бодлогын хүрээнд 26 зорилтын 69 асуудлыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд тусгагдсан сумын ажлууд, СХС, ОНХС-ийн хөрөнгөөр 2016-2018 онд хэрэгжүүлэх ажлын санхүүжилт, өөрийн төсөвт тусгагдсан хөрөнгөөр хэрэгжих арга хэмжээнүүдийг тусгасан байна.

Тус сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа шаардлага хангасан судалгаа хийгээгүй, төлөвлөлтийн шатанд санхүүгийн эх үүсвэрийн үндэслэл, тооцоогүй, нийгэм эдийн засгийн үр дагавар, хүрэх үр дүнг үнэлэх, тодорхойлох арга аргачлал ашиглаагүй, хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа төлөвлөгөө гарган ажиллаагүй байна.

Хөтөлбөрийн боловсруулалтын байдлыг шалгахад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- Үйл ажиллагааны хөтөлбөрийн хувилбаруудад нөхцөл байдлын шинжилгээ хийж, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлсэн асуудлуудыг эрэмбэлээгүй, хянаж боловсруулаагүй нь Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг

журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж эерэг сөрөг нөлөөллүүдийг тооцож гаргаагүй байна.

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр үндсэн чиглэлийн төсөл боловсруулахдаа олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангаж ажиллаагүй, хэлэлцүүлэг зохион байгуулаагүй нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2¹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- Засаг даргын захирамжаар ажлын хэсгийг зохион байгуулж ажилласан боловч бүрэлдэхүүнд нь төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй, харин сум дахь төсөвт газруудын эрхлэгч, захирал, ТГ-ын мэргэжилтнүүдийг багтаасан нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 13 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- Тус ажлын хэсэг нь төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөгүй, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрсийн жагсаалтыг гаргаж ажиллаагүй, хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчмыг баримтлаагүй, төсөл боловсруулах үе шатны ажлуудыг нарийвчлан судлаагүйгээр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрөөс иш татан авсан нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-5.1.7² дахь заалт, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 17-19 дэхь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.
- Арга хэмжээнүүдийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан хэдий ч санхүүгийн эх үүсвэрийг судалгаанд үндэслэн тооцоогүй
- ИТХ-ын ажлын албанд төслийг хүлээлгэн өгөхдөө хавсралт маягтуудыг хөтөлдөггүй, санхүү албанаас зөвшөөрөл авалгүй шууд хурлаар хэлэлцүүлж

1 19.2.Энэ хуулийн 19.1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулж болно:

- 19.2.1.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;
- 19.2.2.эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;
- 19.2.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;
- 19.2.4.төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

2 5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- 5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 5.1.5.нөөц бололцоонд үндэслэсэн байх;
- 5.1.6.ил тод, нээлттэй байх;
- 5.1.7.олон нийтийн оролцоог хангасан байх.

байгаа нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 31 дэх заалттай нийцэхгүй байна.

Хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг нь цуглуулсан мэдээллээ боловсруулах, ач холбогдлоор нь үнэлэх зорилгоор иргэдээс гарсан санал шүүмжийг судлан нягталж, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон давуу, сул талуудыг тодорхойлоогүй байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хувилбаруудад нөхцөл байдлын шинжилгээ хийж, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, олон нийтээр хэлэлцүүлсэн зорилтуудаа Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж эерэг сөрөг нөлөөллүүдийг тооцож гаргаагүй байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа өмнөх жилүүдийн төлөвлөгөө, үндсэн чиглэл сумын төсөвт байгууллагуудын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ОНХС, СХС-ийн 2017-2018 онуудад хийгдэх ажлууд болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн боловсруулсан гэж дүгнэх үндэстэй байна.

1.2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтуудын санхүүгийн тооцооллыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1³.17.2⁴ дугаар зүйлд заасны дагуу холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийж асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг тооцоогүй байна. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁵,18.2⁶ -т заасны дагуу дунд богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 7 дугаар хавсралтаар зорилт бүрээр гаргаагүй байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ БҮРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 бодлогын хүрээнд 26 зорилт 69 арга хэмжээ хэрэгжүүлэхээр үндсэн чиглэлд тусгасан асуудлуудын хөрөнгийн эх үүсвэрийн тооцооллыг асуудал нэг бүрээр үзэж нэгтгэж дүн шинжилгээ хийлээ.

³ 17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

⁴ 17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;

⁵ 18.2.1.улсын болон орон нутгийн төсөв;

⁶ 18.2.2.гадаадын зээл, тусламж;

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Санхүүгийн эх үүсвэрийн төсөөллийг авч үзэхэд:

/Сая.төг/				
д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Зорилтуудын тоо	Хөрөнгийн эх үүсвэр	Эзлэх хувь
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	3	500.0	75.64%
2	Орон нутгийн төсөв	34	-	
3	Дотоод гадаадын төсөл арга хэмжээ	8	40.0	6.05%
4	ОНХС	3	41.0	6.2%
5	ЖДҮДС			
6	ХЭДС	2	-	
7	СХС	5	80.0	12.1%
8	Хувийн хэвшлийн хөрөнгөөр	1	-	
9	БХНСАХЗ			
10	Байгууллагын өөрийн хөрөнгөөр	10	-	
11	Бусад эх үүсвэр	3		
	Бүгд	69	661.0	100%

Нийт санхүүгийн эх үүсвэрийн 75.65%-ийг УТХО-р, 6.05%-ийг дотоод гадаадын төсөл арга хэмжээнээс, 6.2%-ийг ОНХС-ийн хөрөнгөөр, 12.1%-ийг СХС-ийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төсөөлөл хийсэн байна.

Дээрх төсөөллөөс дүгнэлт хийхэд санхүүгийн эх үүсвэрүүдийг бодитой тооцоолоогүй ихэнх дэвшүүлсэн асуудлуудын хөрөнгийн эх үүсвэрүүдийг төсөл хөтөлбөрүүдийн нэрээр ерөнхий тавьж өгсөн байна.

Дэвшүүлсэн асуудлууд нь хэрэгжих магадлал өндөртэй ч өмнө жилүүдээс дамжин ирсэн байгууллагууд дээр жил тутамд хэрэгждэг асуудлууд байгаа бөгөөд санхүүгийн эх үүсвэрийн ихэнх төсөөллийг байгууллагын өөрийн хөрөнгөөр хийгдэнэ гэж төсөөлсөн байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон 2017 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төгсгөлд хийсэн дараахь санхүүгийн эх үүсвэрийн төсөөлөл нь аймгийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн төсөөлөл байна гэж үзлээ.

Санхүүгийн эх үүсвэрийн төсөөллийг авч үзэхэд:

/мянга.төг/				
д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Зорилтуудын тоо	Хөрөнгийн эх үүсвэр/ мянган/	Эзлэх хувь
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт		52990.0	
2	Орон нутгийн төсөв		2394.6	
3	Дотоод гадаадын төсөл арга хэмжээ		146884,0	
4	ОНХС		4775.3	
5	ЖДҮДС		1150.0	
6	ХЭДС		1060.0	
7	СХС		600.0	
9	БХНСАХЗ		420	
11	Бусад эх үүсвэр		100.0	
	Бүгд		230189,0	

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Дээрх тооцооллуудаас дүгнэхэд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн санхүүгийн эх үүсвэрүүдийн тооцооллуудыг бодитой тооцож гаргаагүй, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төсөөлсөн байна.

Сумын засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 07 тогтоолоор баталжээ.


2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг сумын Засаг дарга Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 33-д заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлжээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн товъёог

д/д	Бодлогын нэр	Салбарын нэр	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо
1	Эдийн засгийн хөгжил	Санхүү, эдийн засаг	4
		Хүнс, хөдөө аж ахуй	14
		Дэд бүтэц	12
		1-р бодлогын арга хэмжээний тоо	
2	Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжил	Байгаль орчин	1
		Аялал жуулчлал	1
2-р бодлогын арга хэмжээний тоо		2	
3	Нийгмийн хөгжил	Эрүүл мэнд	8
		Нийтийн биеийн тамир, спорт	1
		Боловсрол	7
		Соёл урлаг	5
		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил	3
		Хөдөлмөр, нийгмийн халамж нийгмийн даатгал,	2
3-р бодлогын арга хэмжээний тоо		26	
4	Засаглал	Төрийн алба	8
		Хууль, эрх зүй	3
4-р бодлогын арга хэмжээний тоо		11	
Нийт арга хэмжээний тоо		69	

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг журмын 31.1-31.7-д заасан хавсралт, мэдээллийн хамт Хурлын ажлын албанд хүргүүлэх ёстой ч шаардлага хангахгүй баримтууд байна.

Сумын ИТХ нь төсөл хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдээс сумын Засаг даргын бүрэн эрхэд нөлөөлөх, ард иргэдийн саналгүй, олон нийтийн эрх ашигт нөлөөлөх



асуудлуудад дүн шинжилгээ хийлгүйгээр шууд 100% баталж байгаа нь Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 33-34 дэх заалтуудыг зөрчиж байна.

Сумын засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 07 тогтоолоор баталжээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого, зорилт, заалтуудыг нягталж үзэхэд сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлтэй уялдаж байгаагаас гадна шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацаа, хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг хөтөлбөрт тусгаж өгөөгүй үндсэн чиглэлд тусгаж өгсөн байна.

1.3.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн тайлагналт хуульд заасан хугацаанд хийгдэж байгаа боловч, хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6⁷, 15 дугаар зүйлийн 15.7⁸, 15.8⁹ дугаар заалтууд, засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд дараахь ажлуудыг хийхээр төлөвлөж сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах үе шаттайгаар зохион байгуулна.

Нэгдүгээр үе шат 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор эхний шатны үнэлгээ хийх

Хоёрдугаар үе шат 2020 оны эхний хагаст эцсийн шатны үнэлгээ хийх:

Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнг бүтэн жилээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцэж байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4¹⁰-д /Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг

⁷ 14.6.Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

⁸ 15.7.Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

⁹ 15.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

¹⁰ 15.4.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.

даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ/ гэсэн заалттай нийцэж байна.

Харин сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулаагүй, ЗДТГ нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэхгүй байгаагаас дүгнэхэд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Өөрөөр хэлбэл Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8¹¹, 20 дугаар зүйлийн 20.1¹² дэх заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Тус сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах байдалтай дүгнэсэн байна.

Үндсэн чиглэлд 82 асуудал хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 46 асуудал 100%, 15 асуудал 70%, 7 асуудал 40%-тай хэрэгжиж, 5 асуудал хэрэгжээгүй 0%-тай, 9 асуудал үндсэн чиглэлд тусгагдаагүй асуудлууд байна.

Үндсэн чиглэлийн асуудлуудыг хэт жижигрүүлж, зарим асуудлыг нэгтгээгүй, дүгнэлт өгөх боломжгүй асуудлуудыг тусгасан гэж үзэх үндэстэй байна

Нийт дундаж оноогоор 73.8%-тай дүгнэсэн биелэлт гаргасан байна. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг сумын ЗДТГ-ын ажилтнууд дүгнэсэн бөгөөд Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэс нь Засгийн газрын 89 дүгээр тогтоолын дагуу үнэлгээ хийгээгүй байна.

Аудитын явцад зарим нэг асуудлуудын хэрэгжилтийг үзэхэд дараахь асуудлууд сайн хэрэгжсэн байна. Үүнд:

- ❖ Дэлхийн банкны төслөөр баригдсан мах, сүүний фермийн барилга баригдаж, тоног төхөөрөмжүүд бүрэн суурилагдсан
- ❖ 2000 ш чацарганы мод суулгаж, төмс хүнсний ногоо тариалж үр дүнгээ өгч эхэлсэн
- ❖ Сумын хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн иргэдийн судалгааг гаргаж 1 иргэнийг гэрээр хангасан
- ❖ Сумын малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлж, сумын аюулгүй нөөцийг ОНХС болон Засаг даргын нөөц сангаас 7639.9 мянган төгрөгийг зарцуулж өвс тэжээл бүрдүүлэн малчдад олгосон тэжээлийн үнэ буцаан төвлөрч байна
- ❖ Сумын 9 жилийн ЕБС-ийн хөтөлбөрийг 12 жилийн



¹¹ 15.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

¹² 20.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэгч байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвийн багцад тусгаж, батлуулсан байна.

боловсролтой болгуулж сургалт явагдаж байгаа үр дүнтэй ажлууд хийгдсэн буюу дараагийн жилүүдэд дамжин хэрэгжих ажлууд байна

Харин хэрэгжээгүй буюу удаашралттай дараах ажлуудад анхаарч ажиллах шаардлагатай байна.Үүнд:

- ❖ Хүнсний ногооны хадгалалтыг сайжруулж зоорь барих
- ❖ Онц болон Соёл багуудыг холбоожуулах
- ❖ Сургуулийн дотуур байрыг засварлах зэрэг хөрөнгө эх үүсвэрийн дутагдалтай ажлуудад дүнэлт хийж ажиллах шаардлагатай гэж үзлээ

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй, аймгаас арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулсан хэдий ч үр дүнгээ өгөөгүй байна .

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийг ИТХ-аар батлуулсан, үйл ажиллагааны хөтөлбөрөө сумдын багийн ИНХ-аар олон нийтэд мэдээлсэн гэх бөгөөд зохион байгуулсан ажил баримтаар нотлогдохгүй байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг нийт ард иргэдэд сурталчилан танилцуулах ажиллагаа хангалтгүй байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1¹³,22.2¹⁴ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна..

Аудитын явцад сумдад ажиллан хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн талаар ажлын хэсгийн ахлан хийж байгаа албан хаагч мэргэжилтнүүдээс аман асуулга хийж тодруулахад хуулиа сайн судлаагүй “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын талаарх мэдлэг мэдээлэл хангалтгүй байлаа.

Аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч буюу холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх албан хаагчдад хуулийн талаар сургалт сурталчилгаа хийгээгүй байна,

Харин Хяналт- шинжилгээ үнэлгээний хэлтсээс арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Бүлэг 2. Сумын төсөвт байгууллагууд төсвийн санхүүжитийг бүрэн авч, холбогдох зардлуудад зарцуулсан байна.

¹³ 22.1.Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

¹⁴22.2.Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.

2.1 Татварын орлогуудын төлөвлөгөөг бүх нэр төрөл дээр жигд биелүүлэх ажилд сумын удирдлагууд, татварын байцаагч нар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох шаардлагатай байна.

Орон нутгийн татварын орлогоор 22920.2 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 35239.0 мянган төгрөгийг төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөөг 53.7%-иар буюу 12319.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл: Суутгагчийн хувь хүнд олгосон татвар 22661.7 мянган төгрөгөөр, галт зэвсгийн албан татвар 170.0 мянган төгрөгөөр давж биелэн үйл ажиллагааны орлогын албан татвар 7984.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 972.0 мянган төгрөгөөр, хүү торгууль, нэр заагдаагүй орлогууд 400.0-1145.0 мянган төгрөгөөр тус тасарсан дүнтэй гарчээ.

Давсан орлогын талаар

- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого, суутгагчийн хувь хүнд олгосон орлогын татвар 8010.3 мянган төгрөгөөр давж биелэсэн нь УИХ-ын 2017.11.09-ны 67 дугаар тогтоолоор олгосон төрийн албан хаагчдад олгосон урамшуулал, нөгөө талаас үйл ажиллагааны орлогын албан татвар гүйгдэн тайлагнагдсантай холбоотой
- Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 4256.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2017.05.01-ээс хууль хэрэгжиж эхэлсэн /ХХОАТ-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1-р заалт/
- Галт зэвсгийн албан татвар 170.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны хураан барагдуулаагүй орлогын үлдэгдэл нөлөөлсөн

Татварын орлогын тасарсан шалтгаан

- Нэр заагдаагүй бусад орлого, хүү торгууль, үйл ажиллагааны орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн орлогууд тасарч байгаа нь төлөвлөгөө бодит байдалтай уялдаагүй хэт өндөр төлөвлөгдсөнтэй холбоотой байна.

Сумын аймагт төвлөрүүлдэг орлогууд нийт дүнгээрээ 6884.5 мянган төгрөг буюу 7.9%-иар 5 нэр төрөл дээр тасарсан байна. Энэ шалтгаан нь төлөвлөгөө бодит байдлаас өндөр төлөвлөгдсөнтэй холбоотой байна.

Орон нутгийн татварын орлого нэмэгдэх нөөц боломж байгаа талаар сумын удирдлагууд болон татварын байцаагч бусад холбогдох ажилтнуудтай ярилцлага хийхэд нөөц боломж бага байгаа талаар ярилаа.

Тухайн суманд ой мод байдгүй нөгөө талаас байгалийн гаралтай жимс жимсгэнэ ургадаггүйгээс гадна сүүлийн жилүүдэд томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээгүй байна.

Харин тус суманд орлого нэмэгдүүлэх гол суурь нь Отгон-тэнгэр хайрхан уулыг зорьсон иргэдтэй уялдуулан аялал жуулчлалын чиглэлээр тодорхой ажил зохион байгуулбал иргэдийн хувийн орлого нөгөө талаас суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос орох орлого нэмэгдэх боломж байна.

АТБӨЯХ-ийн албан татвар 1082.0 мянган төгрөгөөр тасарсан дүнтэй байна. Тус сумын бүртгэлтэй 235 автотээврийн хэрэгсэл, аймгийн тээврийн газарт 325 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй, татварын хэлтсийн tax-act программд нийт АТБӨЯХ-ийн бүртгэлд 415 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаад дүгнэлт хийж бүртгэлийг эрүүлжүүлэх шаардлагатай байна.

Энэ байдлаас дүгнэхэд орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн нутагт байрших тээврийн хэрэгслүүдийн харьяаллыг өөрчлүүлэх, устаж үгүй болсон болон худалдан борлогдсон тээврийн хэрэгслүүдийг тодорхой болгож бүртгэлээс хасуулах, төлөвлөгөөг бодитой төлөвлөхөд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх, бусад татварын орлогуудын төлөвлөгөөг бүх нэр төрөл дээр жигд биелүүлэх ажилд сумын удирдлагууд, татварын байцаагч нар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох шаардлагатай байна гэж үзлээ.

2018 оны татварын орлогын төлөвлөгөөг 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд зарим төрлийн татвар нэр төрөл дээр буурч төлөвлөгдсөнч нийт дүнгээрээ сумын татварын орлого 2012.0 мянган төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх татварын орлого 7464.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэн батлагдаж харин улсын төсвийн орлого 2021.4 мянган төгрөгөөр буурч төлөвлөгдсөн байна.

2016 оны орон нутгийн татварын давсан орлогоос сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын хуралдааны 2017 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 16 тоот тогтоолоор 4667.3 мянган төгрөгийн давсан орлогыг, 2017 оны давсан орлогоос 12 дугаар сарын 20-ны өдрийн 24 тоот тогтоолоор 12319.0 мянган төгрөгийг зарцуулах эрхийг сумын засаг даргад өгч батласан хуваарь, зориулалтын дагуу бүрэн зарцуулж, татварын буцаан олголтоор 10738.7 мянган төгрөгийг олгосон байна.

2017 оны хураан барагдуулаагүй галт зэвсгийн албан татварын ногдуулалт 17*3000-510.0 мянган төгрөгийн татвар байгааг 2018 онд бүрэн барагдуулж оруулах нь зүйтэй гэж үзэн үр өгөөж тооцлоо.

Улсын төсөвт төвлөрдөг татваруудын талаар

Тус суманд бүртгэлтэй 34 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж, НӨАТ төлөгч аж ахуйн нэгж 1 байгаа бөгөөд, Агаарын бохирдлын хураамжийг нийт бүртгэлтэй 235 автотээврийн хэрэгсэлд ногдуулж байгаа бөгөөд НӨАТ бодит байдлаас өндөр төлөвлөгдсөн нь аудитын явцад ажиглагдлаа. Цаашид орлогын төлөвлөгөөг биелүүлэх

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

боломжгүй нэр төрлүүдийн талаар холбогдох газарт уламжилж төлөвлөгөөг бодит байдалтай уялдуулан төлөвлөх нь зүйтэй гэж үзлээ.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

Отгон сум нь 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр 8 төсөл арга хэмжээг 38,75 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд: /сая,төг/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	дүн
1	Баяр наадам	5,0
2	Гамшигийн эрсдлээс урьдчилан сэргийлэх нөөц хөрөнгө	5,0
3	Онц багт өвс тэжээлийн агуулах барих	2,0
4	Соёл багийн төвийг тохижуулах	2,0
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	1,7
6	Тоглоомын талбайн хайс, хамгаалалтыг сайжруулах	15,75
7	Гудамж, хорооллыг хаягжуулах, тохижуулах	2,3
8	Сумын төвийн зам засах	5,0
дүн		38,75

Төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааварт тусгагдсан хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгтэй нийцсэн байна.

Аймгийн ОНХС-аас санхүүжих орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна

Мөн эхний үлдэгдэл санхүүжилтээс Соёл багт холбооны станц байгуулах ажлын 53,0 сая төгрөгийн гэрээг Жи-мобайл ХХК-тай байгуулсан байна. Энэ нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

ОНХС нь 2017 онд 95,7 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэртэй ажилласан байна. Үүнийг судлан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Эхний үлдэгдлээс 55,0 сая төгрөг
- Орон нутгийн төсвөөс 4,0 сая төгрөг
- Аймгийн ОНХС-аас 14,5 сая төгрөг
- ОНХС-ийн урамшуулалаар 22,2 сая төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр урсгал үйл ажиллагааны зардал санхүүжүүлсэн байна.

ОНХС нь 2017 онд 77,5 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна. Зарцуулалтыг судлан үзэхэд төлөвлөгөөнд тусгагдсан 8 төсөл арга хэмжээнээс 6 ажилд

28,0 сая төгрөг, холбооны станц байгуулах ажилд 42,4 сая төгрөг, бусад зардалд 7,1 сая төгрөг зарцуулсан байна.

➤ **Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг авч үзвэл:**

- Баяр наадам 5,0 сая төгрөг,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ 1,7 сая /Цагдаагийн тасагт согтуу шалгах багаж нийлүүлэгдсэн бөгөөд уг хөрөнгийг данс бүртгэлд тусгасан/
- Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх нөөц хөрөнгө 5,9 сая /өвөлжилтийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 400 ширхэг улаан хивгийг худалдан авч нөөцөлсөн/ зэрэг ажлууд бүрэн хийгдсэн байна.

Харин дараах төсөл арга хэмжээнүүд гэрээний хугацаанд хийгдээгүй байна.

- Соёл багийн төвийг тохижуулах 2,0 сая төгрөг /Соёл багийн байрыг тойруулан хашаа болон 00 барих ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан байна/
- Тоглоомын талбайн хайс, хамгаалалтыг сайжруулах ажил 14,1 сая төгрөг / сургуулийн тоглоомын талбайн гадна хайс хийх, тохижуулах ажил/ зэрэг байна.
- Соёл багт холбооны станц байгуулах ажлын гэрээний хугацаа болоогүй бөгөөд станц байгуулах ажлын бэлтгэл хангагдсан гэсэн тайлбарыг холбогдох албан тушаалтангууд ирүүлсэн.



➤ **Бусад зардлыг судлан үзэхэд:**

- Хогийн цэг дээр гэрээт ажилчин ажиллуулж цалин олгосон 0,7 сая төгрөг
- Урсгал зардал болох шатахууны зардал гаргасан 1,0 сая төгрөг
- Нүүдэлчдийн баяр наадмын зардалд 2,0 сая төгрөг
- Баян булаг багт малын угаалгын ванн хийсэн 0,5 сая төгрөг
- Бадрал багт худгийн мотор худалдан авах 1,8 сая төгрөг
- Хогны машины засвар 1,1 сая төгрөг тус тус төлөвлөгөөнд тусгалгүй зарцуулсан байна.



Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааврын 4 дүгээр бүлгийн 4.4 / аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх/ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бусад зардалтай холбоотой 7,1 сая төгрөгийн зарцуулалтаас бадрал багт худгийн мотор худалдан авах ажил хийгдээгүй, санхүүжилтийг хувь хүний дансанд төвлөрүүлсэн 1,8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, урсгал үйл ажиллагааны зардал санхүүжүүлсэн 5,3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3 СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч, албан шаардлагын биелэлтийг хангах шаардлагатай байна.

СХС-ийн 2017 оны орлогыг тулган шалгахад хүүгийн орлогоор 2,5 сая төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс 85,7 сая төгрөг, нийт 88,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан байна.

СХС-ийн 2017 оны дансны хуулгаар орсон орлогыг жилийн эцсийн тайланд тусгагдсан орлоготой тулган үзэхэд 372,9 мянган төгрөгөөр, СХС хариуцсан мэргэжилтэнгийн тайлантай тулгахад 410,88 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байна.

Үүнийг зээлдэгч бүрээр гаргавал дараах байдалтай байна.

д/д	Зээлдэгчийн нэр	Дансны хуулга	
		огноо	дүн
1	Т.Гансүх	2017.01.18	350,000
2	Ц.Лхагвасүрэн	2017.01.25	22,880
3	Ц.Ариунаа	2017.12.01	38,000
	ДҮН		410,880

СХС хариуцсан мэргэжилтэнгийн судалгааны дүн санхүүгийн тайлангийн дүн зөрүүтэй байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

СХС-аас 2017 онд малжуулах зээлд 12 иргэнийг хамруулан 60,0 сая төгрөгийн мал олгож, урсгал зардалд 0,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Урсгал зардал нь малжуулах зээлд хамрагдсан иргэдийн малыг дараагийн иргэдэд шилжүүлэх, хүлээлгэн өгөхтэй холбоотой гарсан зардал бөгөөд зээлийн хүүгийн орлогын 29,8 хувь байгаа нь **Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 1.8 / сангаас олгох зээлийн хүүгийн орлогын 50 хүртэл хувийг сумын ИТХ-ын шийдвэрээр байгуулагдсан төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавих ажлыг зохион байгуулах зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулж болно/** гэсэн заалттай нийцэж байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар 199,5 сая төгрөгийн авлага тайланд тусгаснаас 89,3 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн авлага байсанд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлэн ажилласан байна. Аудитын явцад албан шаардлагын хэрэгжилтийг шалган үзэхэд 16,9 сая төгрөг буюу 18,9 хувь биелэгдсэн байна.

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Мөн 11 иргэнтэй холбоотой 44,2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэхээр шүүхэд хандан эвлэрлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2017 онд 2 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, 8 зорилт бүхий 38 ажил хийхээр төлөвлөж нийтэд ил тод, нээлттэй мэдээлж төлөвлөгөөний биелэлтийг 91 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Отгон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж, хөгжлийн шинэ түвшинд хүргэж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх” эрхэм зорилгын дор Аймгийн ИТХурлын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд Отгон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Тасралтгүй үйл ажиллагаатай, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн сумын ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлж ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлэх” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

2017 онд урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилт 39.2 сая төгрөг, төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж 0.6 сая төгрөг, нийт 39.8 сая төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийг үр ашигтай зарцуулж өр үүсгэлгүй ажилласан байна.

Төсвийн зарлагыг 2017 онд 39.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд зарим зардлын хэтрэлт, хэмнэлтийг хүснэгтээр харуулбал: /сая.төгрөгөөр/

Д/д	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34.48	34.42	0.06
2	Ажил олгогчоос төлөх НДШ	3.74	3.78	-0.04
3	Тээвэр шатахууны зардал	0.22	0.16	0.06
4	Шуудан холбоо, интернетийн төлбөр	0.15	0.19	-0.04
5	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	0.12	0.18	-0.06
6	Мэдээлэл технологийн зардал	0.09	0.05	0.04
	ДҮН	38.80	38.78	0.02

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Зардлыг бүлгээр нь судлан үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 86.4%, нийгмийн даатгалын шимтгэл 9.5%, хангамж, бараа материалын зардал 1.1%, томилолт, зочны зардал 0.9%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 0.6%, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 1.5%-ийг тус тус эзэлж байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь батлагдсан орон тоогоор ажилласан байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 0.2 сая төгрөгийн хүн амын орлогын албан татварын авлагатай гарсан байна.

Иргэдийн хурлын төлөөлөгч нарт хуралд оролцох шатахууны үнэ олгосон, анхан шатны бүрдэл дутуу ажил гүйлгээ данс бүртгэлд тусгасан зэрэг зөрчил нь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны зөрчилтэй давхардсан болно.

Тус Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2017 онд нийт 2 орон тоотой ажилласан бөгөөд удирдах 1, гүйцэтгэх 1 байгаа нь батлагдсан орон тоо байна.

Боловсон хүчний цалин тогтоолтыг судлан үзэхэд алдаа зөрчил илрээгүй бөгөөд албан хаагчдын цалин нь үндсэн цалин, зэргийн нэмэгдэл, онцгой нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ЭБАТ-ны ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлүүдээс бүрдсэн байна.

Боловсон хүчний хөдлөлийн тайлантай танилцахад удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2017 онд элэгдлээрээ зардлаа нөхсөн 3 төрлийн 0.4 сая төгрөгийн хөрөнгийг ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017.12.15-ны өдрийн 42 дугаар тогтоолоор акталсан байна.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан 0.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч нягтлан бодох бүртгэлийн данс бүртгэлд тусган, тооцооны дансаар дамжуулан холбогдох зардлуудад зарцуулсан байна.

Худалдан авсан материалыг няравын тайлантай тулган үзэхэд алдаа зөрчил илрээгүй болно.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Түлш халаалт, тээвэр шатахууны зардлуудын зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулан зардал хямдруулах талаар тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

ЗДТГ төсвөөс авах 232936.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн, орон нутгийн татварын орлогоор 22920.0 мянган төгрөг, 2016 оны давсан орлогын зарцуулаагүй

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

үлдэгдлээс 4667.4 мянган төгрөг, 2017 оны давсан орлогоос 7200.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж нийт 267723.4 мянган төгрөгийн орлоготой үйл ажиллагаа явуулжээ.

ЗДТГ- төвлөрсөн орлогыг бүрэн зарцуулсан бөгөөд төсвийг 3287.4 мянган төгрөгийн давсан орлогоор хэтрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн зарцуулалтыг зардлын нэр төрлөөр авч үзэхэд бараа үйлчилгээний зардал 3887.3 мянган төгрөгөөр хэтэрч бусад зарлууд төлөвлөсөн хэмжээнд зарцуулагдсан байна.

Төсвийн зарцуулалтыг хянаж үзэхэд:

➤ 2017 онд А-80 шатахуун 8411 литрийг 14887.4 мянган төгрөгөөр, ДТ-445 литрийг 878.5 мянган төгрөгөөр, АИ-92 -158 литрийг 290.7 мянган төгрөгөөр 8446 л шатахууны үнэ 16444.3 мянган төгрөгийн зарцуулалтанд ЗДТГ-ын үйлчилгээний машинд хийсэн 1234л шатахуунд жолоочийн замын хуудас бичиж 7212 л шатахуунд замын хуудас бичээгүй удирдлагуудын шатахуун түгээх газруудад жолоочид олгохоор цохсон шатахуунаар зардалд бичсэн зөрчил илэрч байна. Дээрх шатахуун нь ЗДТГ-ын үйлчилгээний машинаас бусад машинд хийсэн мөн багуудын зарцуулсан шатахуун гэсэн тайлбарыг өгч байна.

Шатахууны зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байгаа нь зардал хэтрэх, үрэлгэн зарцуулагдахад хүргэж байгаагаас гадна өглөг үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Замын хуудсанд үйлчилгээний машины спидометрийн заалтыг бүрэн бичүүлж ажил үйлчилгээнд унаж явсан албан тушаалтны хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулан тээвэр шатахууны зардлын гүйцэтгэлийг хянан сар бүр жолоочийн тооцоог бодож МУ-ын Засгийн газрын 2007 оны 349-р тогтоолыг хэрэгжүүлэх шатахууны хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийж байх

➤ Мөн тайлант онд түлш халаалтын зардалд 93.4 тонн нүүрс 13417.7 мянган төгрөгөөр, галын мод 20 м3-ийг 1375.0 мянган төгрөгөөр худалдан авч 1053.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулж нийт 15948.7 мянган төгрөгийн зардал гаргасныг нягталж үзлээ.

ЗДТГ-нь хуучин ашиглаж байсан конторын барилгын халаалтыг хариуцан галлагаа хийдэг нь зардал их гарахад хүргэсэн байна.

Тус конторт ХААН- банк, Төрийн банкны салбарууд хуваариа хөдөлмөр эрхэлж байгаа иргэд өрөө түрээслэн үйлчилгээ эрхэлдэг бөгөөд ХААН банкнаас жилийн түрээсэнд 3480.0 мянган төгрөг, Төрийн банкнаас 1920.0 мянган төгрөг, иргэдээс 1266.0 мянган төгрөг нийт 6666.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлэн тайлан балансад тусгалгүй зарцуулсан зөрчил илэрлээ

Дээрх орлогын хэмжээгээр түлш халаалтын зардал хямдарч хэмнэлт үүсэх байсан боловч төвлөрүүлээгүй суманд ирсэн зочид төлөөлөгч, Отгон- тэнгэр ууланд гарсан ослын үеэр ирсэн хүмүүсийн хоол зэрэгт зарцуулжээ.

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Цаашид дээрх орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулж хяналтыг сайжруулан түлш халаалтын зардлыг хэмнэх, санхүүгийн тайлан балансад орлогыг тусган тайлагнаж байх нь зүйтэй гэж үзлээ.

Нөгөө талаас тус конторыг түрээслэж байгаа банкууд хувь иргэдэд халаалтыг өөрсдөд нь хариуцуулах, бусад оновчтой арга замуудыг олж шийдвэрлэн ЗДТГ-ын төсөвт ачаалал өгч байгаа эрсдэлийг багасгах нь зүйтэй байна.

➤ ЗДТГ-ын төсвөөс 201ш улаан хэвэг 2469.9 мянган төгрөгөөр, 50ш өвс 250.0 мянган төгрөгөөр нийт 2719.9 мянган төгрөгөөр гамшгаас урьдчилан сэргийлэх аюулгүйн нөөц байгуулахад зарцуулсан бөгөөд малчдад зарцуулсан хэвэг, өвсний үнийг санд буцаан төвлөрүүлээгүй хувь хүний дансанд төвлөрүүлсэн зөрчил илэрснээс 2160.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов

Аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулан хөрөнгийн эргэн төлөлтийг хянаж авлага үүсгэхгүй байх, мөн зарцуулалтын тайлан, үлдэгдлийн мэдээг гаргаж байх

Сумын ЗДТГ-ын орон тоо Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 425 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус сумын орон нутгийн захиргааны байгууллагуудын орон тоо бүтцийг шалган үзэхэд ЗДТГ 2015 онд удирдах 3, гүйцэтгэх 9, гэрээт ажилчин 3 үйлчилгээний ажилтан 2, багийн засаг дарга 6 нийт 23 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

2017 онд цалин болон нэмэгдэл урамшууллын зардалд 176196.4 мянган төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 175413.1 мянган төгрөг зарцуулж 783.2 мянган төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан байна.

Аудитын явцад орон тоо цалин тогтоолт, олголтыг тулган шалгасан бөгөөд зөрчил илэрээгүй болно.

Хөрөнгийн хадгалалт, эмх цэгц сайн зориулалтын дагуу ашиглаж байна

Аудитын явцад хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийхэд Буянт, Бадрал багын засаг дарга нарын уналганд зориулсан 2 морь байхгүй, аймгийн Цөм сүргийн үржлийн газраас 2008 онд бүртгэлд авахуулсан ухна 19 толгой 3515.0 мянган төгрөгийн, хуц 71 толгой 13490.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий малыг данс бүртгэлээс хасах шийдвэрийн дагуу хасалт хийгээгүй зөрчил илэрлээ.

Бадрал багын засаг даргын уналгын морь үхсэн бөгөөд эзэмшиж байсан багын засаг дарга Пүрэвсүрэн нас барсан гэсэн тайлбарыг санхүү бүртгэлийн ажилтнууд тайлбарласан тул МЭҮТ-ийн эмч нарын дүгнэлтийг үндэслэн сумын ИТХ-ын тогтоол гаргуулан данснаас хасах, албан үүргээ өгсөн Буянт багын засаг дарга

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Б.Эрдэнэбилэгээс уналгын морийг дансны 200.0 мянган төгрөгөөр төлбөр болгон орон нутгийн төсөвт оруулахаар төлбөрийн акт тогтоов

2017, 2018 оны жилийн эцэст хөрөнгийн тооллогыг нүд үзэн тоолж бүртгэлийн акт үйлдсэн бөгөөд дээрх зөрчлүүдээс өөр зөрчил илрээгүй байгууллагын санхүүгийн баримтын эмх цэгц сайн, бүртгэл хөтлөлтийг шаардлагын хэмжээнд хүргэсэн, төсвийн зарцуулалтанд тавих төрийн сангийн хяналт сайн байна.

Аудитаар ЗДТГ-ын үйл ажиллагаатай холбоотой 19569.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 2360.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Байгууллагын үйл ажиллагааны дэвшүүлсэн зорилтоо үр дүнтэй биелүүлжээ

Тус сургууль нь 2017 онд 368 суралцагч, 54 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, 29 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн биелэлтийг тооцон ажилласан байна. Үүнээс: 90-100 хувийн гүйцэтгэлтэй 19, 70-80 хувийн гүйцэтгэлтэй 7, 70-с доош хувийн гүйцэтгэлтэй 3 арга хэмжээ байна.

Дээрхи байдлаас дүгнэхэд сургуулийн төлөвлөсөн үйл ажиллагааны биелэлт 86,9 хувьтай байна гэж үзлээ.

Мөн 2017 онд ЕБС-ийг 12 жилийн сургалттай болгосон нь үр дүнтэй ажил болсон байна гэж үзлээ. Энэ нь суралцагчдын тоо өсөх, шилжилт хөдөлгөөн багасах зэрэг давуу талыг бий болгосон байна.

ЕБС нь 12 жилийн сургалттай болсоноор бичиг хэрэг, гэрэл цахилгаан, ном хэвлэл зэрэг байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардал нэмэгдэх эрсдэлтэй байна гэж үзлээ.

2017 онд урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилт 547,8 сая төгрөг, насан туршлын болон албан бус боловсролын зардлын санхүүжилт 2,0 сая төгрөг, төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж 16,2 сая төгрөг, бусад орлогоор 0,2 сая төгрөг нийт 566,2 сая төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг бодитой төлөвлөөгүй байна.

Төсвийн зарлагыг 2017 онд 550,7 сая төгрөгөөр баталсан бөгөөд тодотгол хийж 3,0 сая төгрөгөөр бууруулан баталж, зарим зардлын хооронд зохицуулалт хийсэн байна. Тухайлбал:

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

/ сая.төг/

д/д	Зардлын ангилал	Анх батлагдсан	Тодотгосон	Зөрүү
1	Үндсэн цалин	238,4	237,2	-0,6
2	Ажил олгогчоос төлөх НДШ	38,8	38,7	-0,1
3	Гэрэл цахилгаан	4,7	5,5	0,8
4	Бичиг хэрэг	0,4	1,0	0,6
5	Тээвэр шатахуун	1,1	2,5	1,4
6	Хоол хүнс	30,9	24,2	-6,7
7	Эд хогшил, урсгал засвар	1,2	2,2	1,0
8	Дотоод албан томилолт	0,3	1,0	0,7
	ДҮН			-3,0

Хоолны зардлыг төлөвлөхдөө дотуур байрыг бүрэн хүчин чадлаар /75 хүүхэд/ ажиллахаар тооцсон нь бодит байдалтай нийцэхгүй байна. Энэхүү байдалтай уялдуулан төсөвт тодотгол хийж хоолны зардлыг бууруулан баталжээ.

Төсвийг үр ашигтай зарцуулж өр, авлага үүсгэлгүй ажилласан байна.

ЕБС нь 2017 онд нийт 566,2 сая төгрөгийн зардалтай үйл ажиллагаа явуулсан байна.

Зардлыг бүлгээр нь судлан үзэхэд цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого, нийгмийн даатгалын шимтгэл 69,1 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8,2 хувь, нормативт зардал 4,5 хувь, тэтгэмжийн зардал 15,3 хувь, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой бусад зардал 9,7 хувь байна.

Төсөвт тодотгол хийж, зарим зардалд зохицуулалт хийсэн хэдий ч бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчил байна. Тухайлбал: Цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмнэлт 1,6 сая төгрөгийг хангамж бараа материалын зардал болох бичиг хэрэг, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс зэрэг зардлуудад зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5 дугаар бүлгийн 5.1 "Төсвийн байгууллага энэ журмын 3.1.4-т заасан үндэслэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шитгэлийн зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс бусад зардлын бүлэг хооронд жилийн батлагдсан төсвийн тухайн зардлын бүлгийн дүнг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх зохицуулалтын хүсэлт гаргаж болно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаар илрүүлсэн үр дүнгийн урамшуулал авсан, хувь хүнээс орлогын албан татвар суутган тооцоогүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ данс бүртгэлд тусгасан зэрэг зөрчил нь аймгийн засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албаны зөрчил төлбөртэй давхардсан болно.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2 удаа шалгалт хийж 3,0 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьсан байна.

Төсвийн зарцуулалтыг судлан үзээд төрийн албан хаагчдад олгох ажлын үр дүнгийн урамшууллыг сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа 8 албан хаагчдад олгосон 2,2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

Боловсон хүчин тогтвор суурьшилтай байна.

ЕБС нь 2017 онд нийт 54 орон тоотой ажилласан бөгөөд удирдах 1, гүйцэтгэх 29, үйлчлэх 12, гэрээт 12 байгаа нь батлагдсан орон тоо байна.

Боловсон хүчний цалин тогтоолтыг судлан үзэхэд алдаа зөрчил илрээгүй бөгөөд албан хаагчдын цалин нь үндсэн цалин, зэргийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, анги даалт, заах аргын нэмэгдэл зэрэг нэмэгдлүүдээс бүрдсэн байна.

ЕБС-ийн багшлах боловсон хүчний 7 нь магистер зэрэгтэй, 17 нь заах аргач мэргэжлийн зэрэгтэй, 1 нь тэргүүлэх зэрэгтэй байгаа нь боловсон хүчин бэлтгэгдсэн байна гэж үзэхээр байна.

Боловсон хүчний нийгмийн хамгааллын байдалд анхаарч 14 багшид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 42,8 сая төгрөг, 2 багшийн ар гэрийг малжуулах төсөлд хамруулсан байна.

Боловсон хүчний хөдлөлийн тайлантай танилцахад шилжсэн 1, жирэмсэний амралт авсан 4 албан хаагч байгаагаас үзэхэд ЕБС-ийн боловсон хүчин нь тогтвор суурьшилтай ажиллаж байна гэж үзлээ.

Санхүүгийн ажилчдын хоорондын ажлын уялдаа нягт биш байгаа нь санхүүгийн зөрчил илэрхэд нөлөөлж байна.

ЕБС нь 2017 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2,8 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, БСШУ-ны сайдын хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 1,3 сая төгрөгийн номыг данс бүртгэлд тусган, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аудитаар үндсэн хөрөнгө болон түүний ашиглалт хамгаалалттай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан 103,9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч нягтлан бодох бүртгэлийн данс бүртгэлд тусган, тооцооны дансаар дамжуулан холбогдох зардлуудад зарцуулсан байна.

Гэтэл эдгээр материалыг няравын тайлантай тулган үзэхэд худалдан авсан материалыг бүртгээгүй, зарим материалын тайланг гаргаагүй зэрэг алдаа илэрсэн болно.

Нягтлан бодогч тайлангаа гаргахдаа няравын тайланд үндэслэн данс бүртгэл хөтөлдөггүй, няравын үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй, зааж сургадаггүй, ажлын хоорондын уялдаа холбоо байхгүй зэрэг дутагдал байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цаашид няравын тайлан гаргалтанд анхаарч, түүний гаргасан тайланд үндэслэн бүртгэл хөтлөж хэвших шаардлагатай байна.

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Тус байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хуулиар хүлээсэн үүргээ бүрэн тусгаж, зорилго зорилтоо үнэн зөв тодорхойлжээ.

Тус байгууллага нь Отгон сумын сумын Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 4 төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэхээс 3 төрлийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. Мөн 1 төрлийн арга хэмжээ буюу хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 16 сая төгрөгийн төсөл бичсэн боловч санхүүжилт хүрэлцээгүйтэй холбоотой хэрэгжээгүй байна.

Аймгийн Засаг дарга бөгөөд төсвийн Ерөнхийлөн захирагч болон цэцэрлэгийн эрхлэгч хооронд байгуулсан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх дөрвөлсөн гэрээ байгуулан ажиллажээ.

Тус гэрээг үндэслэн Боловсролын талаар дэвшүүлсэн зорилтуудыг үндэслэн 2017-2018 оны хичээлийн жилд боловсролын байгууллагын багш ажиллагсадын ажлын хариуцлага, ёс зүй, эерэг хандлагыг эрхэмлэн, шударга хүртээмжтэй боловсролын үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн эрүүл аюулгүй орчин бий болгоно гэсэн 5 зорилт дэвшүүлэн ажиллажээ.

- Боловсролын салбарын эрх зүй, бодлого төлөвлөлт.
- Сургуулийн өмнөх боловсролын чанар хүртээмжийг сайжруулах.
- Багшийн мэргэжлийн үнэлэмжийг дээшлүүлэх.
- Тусгай хэрэгцээт боловсрол
- Орчин бүрдүүлэлтийг сайжруулах зорилт дэвшүүлжээ.

Нэгдүгээр зорилтын хүрээнд 3 арга хэмжээ, хоёрдугаар зорилтын хүрээнд 4 арга хэмжээ, гуравдугаар зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, дөрөвдүгээр зорилтын хүрээнд 1

арга хэмжээ, тавдугаар зорилтын хүрээнд 3 арга хэмжээ нийт 13 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Отгон сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн Аймгийн засаг даргатай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг үзэхэд 82,45 хувьтай үнэлэгдсэн бөгөөд аймгийн хэмжээнд нийт 36 цэцэрлэг байгаагаас 21-р байранд орсон үзүүлэлтэй байна.

Аудитын явцад хэрэгжсэн арга хэмжээ, ажил үйлчилгээг анхан шатны суурь судалгаа болон хийгдсэн ажлуудын тайлангуудтай тулгахад дээрх үнэлгээ бодитой байна гэж үзлээ.

Тус байгууллагын 2017 онд Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, Багш ажиллагсдын хүртээмж, чанарыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үр нөлөөтэй зарим арга хэмжээнүүдээс дурьдвал:

1. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ хэрэгжүүлэх чиглэлээр

- СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд багуудын хурал, малын тооны ажлын хүрээнд явж 2-5 настай хүүхдийн судалгааг нүүдлийн бүлэг ажиллуулах малчдын санал хүсэлтийг авсан.
- Цэцэрлэгийн үндсэн бүлэгт хамрагдагсад, ээлжийн болон нүүдлийн бүлэгт суралцагчдын бүртгэл, тэдний хөгжлийн ахиц өөрчлөлтийг хүүхэд нэг бүрийн хувийн хавтасыг нээж багш нар хөтлөн боловсролын мэдээллийн санд нэвтрүүлсэн.
- Сумын хэмжээнд амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой 7 хүүхдийг хичээлийн болон ариун цэврийн хэрэгслийг 100% хөнгөлж, хөнгөн хүнд хэлбэрийн тусгай хэрэгцээт боловсрол шаардсан 4 хүүхэд цэцэрлэгт хамруулан ажилласан байна.

2. Багш ажиллагсдын хүртээмж чанарыг хангах чиглэлээр

- Албан хэрэг хөтлөлтийг өмнөх онтой харьцуулахад ахиц гарч 2017 онд аймаг, болон сумаас авч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Исатком ХХК-тай хамтран ажиллаж интернеттэй болсон, Мөн багш нар I mail хаягтай болсон зэрэг ахиц гарчээ.
- Багш ажиллагсдын оролцоог байгууллагын бүхийл үйл ажиллагаанд оролцуулан ажиллаж байна.

Хэрэгжилт нь 70 хувиар дүгнэгдсэн ажил үйлчилгээг тодруулахад үе шаттайгаар дараагийн жилүүдэд хэрэгжих буюу тодорхой шалтгааны улмаас гүйцэтгэл, үр дүн нь бүрэн гараагүй арга хэмжээнүүд байна.

Харин хэрэгжилт нь 0 хувиар дүгнэгдсэн ажил үйлчилгээний хувьд хэрэгжих боломжгүй буюу хөрөнгө санхүүгийн хүрэлцээгүйтэй холбоотой, мөн багш солилцоо хөтөлбөр гэхэд тухайн товолсон сумын цэцэрлэгийн багш нар боломжгүй гэх мэт ажил үйлчилгээ төлөвлөсөнтэй холбоотой байна.

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Тус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажил үйлчилгээнүүд нь хэт нуршсан, асуудлыг жижигрүүлж задалсан, хэрэгжих боломжгүй буюу хөрөнгө эх үүсвэр нь тодорхой биш, утга санаа давхардсан ажил үйлчилгээг тусгасан дутагдал байна.

Цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргахдаа холбогдох хуулинд заасан үүрэг, оролцоог үндэслэн, хэрэгжих боломжтой үр нөлөөтэй ажил үйлчилгээг тодорхой онож тусгах шаардлагатай байна гэж үзлээ.

Улсын төсвөөс авсан санхүүжилтийг бүрэн зарцуулсан байна.

2017 онд батлагдсан санхүүжилтээ бүрэн авч, нэмэлт санхүүжилтээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 1375,0 мянган төгрөгийн, нийт 184976,8 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Тус байгууллага нь тайлант хугацаанд 183601,8 мянган төгрөгийн зарлагатай ажилласан байна.

Зардлын зүйлийг эдийн засгийн ангилалаар нь авч үзэхэд: /мян.төг/

д/д	Зардлын зүйл	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хэмнэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107924,0	107924,0		
2	НДШ	11871,6	11988,8	-117,2	
3	Гэрэл цахилгаан	2080,0	1015,7		1064,3
4	Түлш халаалт	11308,6	12300,9	-992,3	
5	Цэвэр бохир ус	825,0	680,4		144,5
6	Бичиг хэрэг	200,0	246,0	-46,0	
7	Тээвэр шатахуун	1300,0	1300,0		
8	Шуудан холбоо	1775,8	1729,5		46,3
9	Ном хэвлэл	54,7	20,0		34,7
10	Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс	500,0	535,0	-35,0	
11	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	62,5	95,0	-32,5	
12	Хоол хүнс	34000,0	34000,0		
13	Урсгал засвар	1310,0	1310,0		
14	Томилолт	280,0	280,0		
15	Бараа үйлчилгээний бусад зардал		733,5	-733,5	
16	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	933,4	199,2		734,2
17	Нэг удаагийн тэтгэмж	4800,0	4800,0	0	

Хэтэрсэн болон хэмнэгдсэн зардлууд нь дараах шалтгаантай байна.

- НДШ-ийн зардлыг 117,2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн шалтгаан нь Галч нарын ажиллаагүй үеийн НДШ-ийг төлсөн учраас
- Түлш халаалтын зардал 992,3 мянган төгрөгөөр хэтэрсэн нь гэр цэцэрлэгийг галладаг учраас
- Бичиг хэргийн зардлын төлөвлөгөө бага материалын үнэ өндөр үнэтэй байдаг учраас тус тус хэтэрсэн байна.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илрүүлээ.

- Жолоочийн замын хуудсаарх тооцоог бодоогүй, автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй, шатахуун зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт байхгүй 4442,1 мянган төгрөгийг зарцуулсан.
- Дуудсан бичиггүйгээр томилолтын зардал гаргаж 69,3 мянган төгрөгийг олгосон зэрэг нийт 4511,4 мянган төгрөгийн зөрчил илрүүлээ.

Цаашид төсвийн зарцуулалттай холбоотой дээрх дутагдлуудыг дахин давтахгүй байж, хичээллэж буй дугуйлангуудын орлогыг байгууллагын дансаар дамжуулан гүйлгээ хийж орлого зарлагыг бүртгэж байх нь зүйтэй гэж үзлээ.

Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт эмх цэгцтэй байна.

Аудитын явцад хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай газар дээр нь танилцаж, хэсэгчилсэн тооллого хийлээ.

Хэсэгчилсэн тооллогоор хөрөнгийн дутагдал гараагүй болно.

Байгууллагын тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг эзэмшиж буй ажилтнуудад картаар эзэмшүүлсэн байна.

2017 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамнаас 1350,0 мянган төгрөгийн компьютерийг орлогод бүрэн тусгаж, ашиглаж байна.

Тус байгууллагын бүртгэлд байгаа боловч, анхны өртгөөрөө элэгдэлээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн жагсаалт гарган актлуулах шийдвэр гаргуулахаар холбогдох газарт хүргүүлсэн байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Тус Эрүүл мэндийн төв нь 2017 онд 25 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, сумын 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэсний 10 хөтөлбөр, стратеги 16 хөтөлбөр, нийт 26 хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн биелэлтийг тооцон ажилласан байна. Үүнээс: 96-100 хувийн гүйцэтгэлтэй 8, 90-95 хувийн

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

гүйцэтгэлтэй 18 арга хэмжээ байна. Тус байгууллагад 2017 онд Эрүүл мэндийн яам болон аймгийн Эрүүл мэндийн газраас 4 үндэсний хөтөлбөр, 10 стратеги хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгагдсан боловч 1 стратеги /Өрхийн эрүүл мэнд/ хөтөлбөр хэрэгжээгүй, бусад 13 үндэсний болон стратеги хөтөлбөрүүд 90-100 хувьтай хэрэгжсэн байна.

Дээрхи байдлаас дүгнэхэд Эрүүл мэндийн төвийн төлөвлөсөн үйл ажиллагааны биелэлт 90-ээс дээш хувьтай байна.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт 2017 онд 40-65 насны нийт хамрагдах 590 хүнээс 531 хүн буюу 90 хувийг хамруулж 16 төрлийн шинжилгээ авч В вирустэй 72, С вирустэй 43 иргэнийг илрүүлж ажилласан нь үр дүнтэй ажил болсон байна.

Отгон сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлүүлэгчдийн эрхийг дээдэлсэн, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан тэгш хүртээмжтэй, чанартай эмнэлгийн тусламжийг эрхэмлэе” эрхэм зорилгын дор Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд тус Эрүүл мэндийн төв нь:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулж, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах
2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны хариуцлагыг дээшлүүлж сайжруулах
3. Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм биобэлдмэлээр жигд хүртээмжтэй, тасралтгүй хангах зэрэг зорилт дэвшүүлэн ажиллажээ.

2017 онд урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилт 279.8 сая төгрөг, төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж 6.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор 1.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 0.7 сая төгрөг, нийт 287.9 сая төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийн зарлагыг 2017 онд 285.1 сая төгрөгөөр баталсан бөгөөд зарим зардлын хэтрэлт, хэмнэлтийг хүснэгтээр харуулбал: /сая.төгрөгөөр/

д/д	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн цалин	177.8	177.6	0.2
2	Ажил олгогчоос төлөх НДШ	19.5	19.7	-0.2
3	Гэрэл цахилгаан	1.8	1.6	0.2
4	Түлш халаалт	12.9	13.5	-0.6
5	Цэвэр, бохир ус	0.06	0.2	-0.14
6	Шуудан холбоо, интернет	0.7	0.0	0.7
7	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1.3	1.1	0.2
8	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	14.4	19.0	-4.6

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

9	Хоол, хүнс	5.9	3.6	2.3
10	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.5	0.4	1.1
11	Урсгал засвар	1.0	1.6	-0.6
12	Дотоод албан томилолт	0.9	0.6	0.3
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	12.7	12.2	0.5
14	Мэдээлэл технологийн зардал	0.5	1.1	-0.6
15	Бараа үйлчилгээний бусад зардал	6.6	6.4	0.2
	ДҮН	257.6	258.6	-1.0

Тус Эрүүл мэндийн төв нь 2017 онд нийт 312.7 сая төгрөгийн зардалтай үйл ажиллагаа явуулсан байна.

Зардлыг бүлгээр нь судлан үзэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 62.1%, нийгмийн даатгалын шимтгэл 6.9%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5.4%, хангамж, бараа материалын зардал 6.9%, нормативт зардал 8.1%, эд хогшил худалдан авах зардал 1.3%, томилолт, зочны зардал 0.2%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 4.8%, бараа үйлчилгээний бусад зардал 2.2%, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 2.1%-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн сувилагч нарын илүү цагийн хөлс, төрийн албан хаагчид олгох нэг удаагийн урамшуулал, хувь хүнээс орлогын албан татвар суутган тооцоогүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ данс бүртгэлд тусгасан зэрэг зөрчил нь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны зөрчил, төлбөртэй давхардсан болно.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2018 оны 05 сард шалгалт хийж 2,5 сая төгрөгийн төлбөрийн акт тавьсан байна.

Төсвийг үр ашигтай зарцуулж өр, авлага үүсгэлгүй ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь 2017 онд нийт 25 орон тоотой ажилласан бөгөөд удирдах 1, гүйцэтгэх 15, үйлчлэх 5, гэрээт 4 байгаа нь батлагдсан орон тоо байна.

Боловсон хүчний цалин тогтоолтыг судлан үзэхэд алдаа зөрчил илрээгүй бөгөөд албан хаагчдын цалин нь үндсэн цалин, зэргийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдлүүдээс бүрдсэн байна.

Удирдах болон гүйцэтгэх ажилтнууд нь бүгд анагаах ухааны сургууль төгссөн, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдсэн байна гэж үзлээ.

Тус Эрүүл мэндийн төв нь батлагдсан орон тоогоор ажилласан байна.

Эрүүл мэндийн төв нь 2017 онд төсвийн хөрөнгөөр судас тодотгогч-1, мөнгөн устай даралтны аппарат-2, багийн эмч, их эмч нарт пульсоксиметр-7, нярайн пульсоксиметр-1, цусны аппарат-1 зэргийг худалдан авч данс бүртгэлд тусган, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Аудитын явцад хэгэсчилсэн тооллого хийхэд хөрөнгө дутагдаагүй болно.

СОЁЛЫН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Тус байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хуулиар хүлээсэн үүргээ бүрэн тусгаж, зорилго зорилтоо үнэн зөв тодорхойлжээ.

Тус байгууллага нь Отгон сумын Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 4 төрлийн арга хэмжээ тусгагдсан бөгөөд өөрийн төлөвлөгөө хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар газар дээр нь үзэх боломжгүй Соёлын төвийн эрхлэгч Улаанбаатар хотруу явсан байлаа.

Байгууллагын дэвшүүлсэн асуудлууд сумын засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан бөгөөд ажлаа дүгнүүлж үр дүнгээ тооцуулсан байна.

Улсын төсвөөс авсан санхүүжилтийг бүрэн зарцуулсан байна.

А. 2017 оны орлого бүрдүүлэлтийн байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Он сар	Орлогын дүн сараар
2	2017-02	30000
3	2017-03	214000
4	2017-04	146000
5	2017-05	370000
9	2017-09	29000
10	2017-10	41500
11	2017-11	487500
12	2017-12	970000
	Нийт дүн	2288000

2017 онд батлагдсан санхүүжилтээ бүрэн авч, нэмэлт санхүүжилтээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон бусад хандив тусламжаар 2075,0 мянган төгрөгийн ном, түүх соёлын дурсгалт зүйл, тавилга хэрэгсэл авсан, мөн өөрийн орлогоор 2288,0 мянган төгрөг нийт 46452,9 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

Мөн үзелийн орлогыг өдөр бүр банкин дахь дансанд тушааж сар бүр тооцоог хийж хэвших нь зүйтэй гэж үзлээ. Бичиг хэргийн зардлын төлөвлөгөө бодит байдлаас хэт доогуур төлөвлөгдсөн учраас хэтрэлт байнга гардаг байна

Б. Төсвийн зарцуулалтын талаар

Тус байгууллага нь тайлант хугацаанд 46452,9 мянган төгрөгийн зарлагатай ажиллаж батлагдсан төсвийг 1290,7 мянган төгрөгийн хэтрүүлэн ажилласан байна.

Зардлын зүйлийг эдийн засгийн ангилалаар нь авч үзэхэд:

/мян.төг/

д/д	Зардлын зүйл	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Хэмнэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29695,5	30867,1	-1171,6	
2	НДШ	3266,6	3394,4	-127,8	
3	Гэрэл цахилгаан	553,8	523,6		30,1
4	Түлш халаалт	7026,4	6445,5		580,8
5	Цэвэр бохир ус	60,0	46,0		14,0
6	Бичиг хэрэг	87,6	150,2	-62,6	
7	Тээвэр шатахуун	170,0	186,1	-16,1	
8	Шуудан холбоо	40,0			
9	Ном хэвлэл	60,0	35,0		25,0
10	Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс	60,0	58,0		2,0
11	Урсгал засвар	150,0	720,0	-570,0	
12	Томилолт	167,0	167,0		
13	Бараа үйлчилгээний бусад зардал		55,0	-55,0	
14	Нормын хувцас зөөлөн эдлэл	40,0	40,0		
15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	2155,3	2204,7	-49,0	
16	Нэг удаагийн тэтгэмж	1500,0	1500,0		

Хэтэрсэн болон хэмнэгдсэн зардлууд нь дараах шалтгаантай байна.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1171,6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Соёлын төвийн эрхлэгч солигдож өмнөх эрхлэгч нь шүүхийн шийдвэрээр дахин орсон учраас цалингийн зардал хэтэрсэн. Хэтрэлт нь өөрийн орлогоос санхүүжсэн байна.
- НДШ-ийн зардлыг 127,8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь цалингийн сантай холбоотойгоор.
- Түлш халаалтын зардал 580,8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь өмнөх оны түлээний модны үлдэгдэл нөлөөлсөн
- Урсгал засварын зардал 570,0 мянган төгрөгөөр хэтэрсэн нь Музейн өрөөнд засвар хийснээс
- Бичиг хэргийн зардлын төлөвлөгөө бодит байдлаас бага төлөвлөгдсөнтэй тус тус холбоотой байна.

- Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчил илрүүлээ.
 - Жолоочийн замын хуудсаарх тооцоог бодоогүй, автомашины шатахуун зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй, шатахуун зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт байхгүй 103,8 мянган төгрөгийн.
 - Баримтын бүрдүүлэлт дутуу, дуудсан бичиггүйгээр томилолтын зардал гаргасан, энгэрийн тэмдэгний үнэ давхардуулан олгосон 354,8 мянган төгрөгийн.
 - Сахилгын шийтгэлтэй байсан үйлчлэгч Ч.Отгончимэгт нэг удаагийн тэтгэмж урамшуулал болох 270,0 мянган төгрөгийг олгосон зэрэг нийт 728,6 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэнээс 270,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоогдлоо.

Цаашид төсвийн зарцуулалттай холбоотой дээрх дутагдлуудыг дахин давтахгүй байж, өөрийн орлогыг байгууллагын дансаар дамжуулан гүйлгээ хийж орлого зарлагыг бүртгэж байх нь зүйтэй гэж үзлээ.

Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалт эмх цэгцтэй байна.

Аудитын явцад хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай газар дээр нь танилцаж, хэсэгчилсэн тооллого хийлээ.

Хэсэгчилсэн тооллошоор хөрөнгийн дутагдал гараагүй болно.

Байгууллагын тавилга эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг эзэмшиж буй ажилтнууд дээр карталж эзэмшүүлсэн байна.

Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүн

2017 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамнаас болон хандив тусламжаар 2075,0 мянган төгрөгийн хөрөнгө өгсөнийг орлогод бүрэн тусгаж, ашиглаж байна.

Тус байгууллагын бүртгэлд байгаа боловч, анхны өртгөөрөө элэгдэлээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийн жагсаалт гарган актлуулах шийдвэр гаргуулахаар холбогдох газарт хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 28979,3 мянган төгрөгийн зөрчил илэрүүлэн 6660,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож 12100,0 мянган төгрөгийн санхүүгийн, 4 санхүүгийн бус үр өгөөж бүртгэн харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн ажиллаа.

Дүгнэлт: Төсөвт байгууллагууд нь Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд тусгасан төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

ДАРГА,БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
нарийн бичгийн дарга Ж.Мөнхбат-д

Монгол Улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Хүн амын орлогын албан татварын илүү төлсөн 0.2 сая төгрөгийг 2018 оны эхний хагас жилд суутган тооцож, авлагын үлдэгдлийг хаах
2. Иргэдийн Хурлын төлөөлөгч нарт хуралд суух шатахууны зардлыг төсвөөс гаргахгүй байх

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Засаг дарга Ж.Амгаланбаяр-т

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “ Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

1. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж байх
2. Хөтөлбөрт хуульд заасан хугацаанд хяналт-шинжилгээ, хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, ажлын тайланг баримтжуулж, мэдээлэх
3. Цаашид хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төсөөлөл хийж байх
4. Татваруудын орлогын төлөвлөгөөг бүх нэр төрөл дээр жигд биелүүлэх ажилд сумын удирдлагууд, татварын байцаагч нар тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох .
5. Түлш халаалт, тээвэр шатахууны зардлуудын зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулан зардал хямдруулах талаар тодорхой ажил зохион байгуулах
6. Конторын барилгыг түрээсэлж байгаа банкууд хувь иргэдийн түрээсийн орлогыг нэмэлт дансаар дамжуулан зарцуулж тайланд тусгаж байх
7. Аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулан хөрөнгийн эргэн төлөлтийг хянаж авлага үүсгэхгүй байх, мөн зарцуулалтын тайлан, үлдэгдлийн мэдээг гаргаж тайлагнаж байх
8. Замын хуудсанд үйлчилгээний машины спидометрийн заалтыг бүрэн бичүүлж ажил үйлчилгээнд унаж явсан албан тушаалтаны хүлээн зөвшөөрсөн гарын үсгийг зуруулан тээвэр шатахууны зардлын гүйцэтгэлийг хянан сар бүр жолоочийн тооцоог бодож МУ-ын Засгийн газрын 2007 оны 349-р тогтоолыг хэрэгжүүлэх шатахууны хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийж байх

Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн хариуг 2018 оны 09 сарын 20-ны дотор албан тоотоор ирүүлэхийг мэдэгдье.

ДАРГА,БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Ерөнхий боловсролын сургуулийн
захирал Д.Цэнд-Аюуш-д

Монгол улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Төсвийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох эрх бүхий байгууллагад хүсэлт уламжлан, төсөвт зохицуулалт хийж байх
2. Нягтлан бодогч, нярав нарын ажлын уялдааг сайжруулан, бараа материалын тайланг нэр төрлөөр нь тухай бүр гаргаж хэвшүүлэх
3. Биеийн тамирын заалыг аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд түрээслүүлж, орлогыг данс бүртгэлээр дамжуулан зарцуулах

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Ж. Өнөргэрэл-д

Монгол улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Үйл ажилгааны төлөвлөгөөг боловсруулахдаа дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжих боломжтой, утга давхардахгүй, үр нөлөөтэй ажил үйлчилгээг тусгах.
2. Сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд асуудал оруулахдаа сум орон нутагт хэрэгжих боломжтой, төсөв санхүүгийн эх үүсвэрийг тооцож оруулж байх
3. Жолоочийн замын хуудас бичиж байх, зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх
4. Төсвийн зарцуулалтыг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж байх.

ДАРГА, БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Эрүүл мэндийн төвийн
эрхлэгч их эмч Г.Наранцэцэг-т

Монгол Улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Отгон сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны зардалд эрхлэгч их эмч, нягтлан бодогч нар хяналт тавьж тавих
2. Алсын дуудлагын болон өвчтөн шилжүүлэх бүртгэлийг бүрэн хөтлөж хэвших
3. Тээвэр шатахууны зардалд шат дараалсан хяналт тавих, багийн эмчийн болон гадны машинаар үйлчлүүлсэн шатахууны зардалд жолоочийн тооцооны хуудас хөтлөж хэвших

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Соёлын төвийн эрхлэгч А.Сосорбурам-д

Монгол улсын Ерөнхий аудиторт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Отгон сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Үйл ажилгааны төлөвлөгөөг боловсруулахдаа Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/, Боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүд, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2030/ хөтөлбөрүүдэд талаар дэвшүүлсэн зорилтуудыг үндэслэн, хэрэгжих боломжтой, утга давхардахгүй, үр нөлөөтэй ажил үйлчилгээг тусгах.
2. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд зорилт арга хэмжээ оруулахдаа сум орон нутагт хэрэгжих боломжтой, төсөв санхүүгийн эх үүсвэрийг тооцож оруулах
3. Өөрийн орлогыг сар бүр жигд оруулах, орлого нэмэгдүүлэх талаар санаачлагатай ажиллах.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА, БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР